



2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

САЙНШАНД САЛХИН ПАРК ТӨСӨЛ

Улаанбаатар хот 2023 он

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Сайншанд-Салхин Парк” ХХК-ийн Гүйцэтгэх Захирал



Э.МЯГМАРДОРЖ

САЙНШАНД САЛХИН ПАРК ТӨСЛИЙН 2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 5286301/

Боловруулсан:
ХАББОХ мэргэжилтэн

A handwritten signature in black ink, appearing to read "С. Намжилмаа".

С.НАМЖИЛМАА

ОРШИЛ.....	4
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1.Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	5
1.2 Төслийн байршил.....	5
1.3 Төслийн хүчин чадал.....	6
1.4 Төслийн дотоод зам.....	9
1.5 Хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл.....	10
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭЖ БУЙ ОРОН НУТГИЙН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	12
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	13
3.1. Агаар мандалд үзүүлэх нөлөөлөл.....	13
3.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл.....	13
3.4. Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	13
3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	13
3.6. Түүх соёлын дурсгалт зүйлд үзүүлэх нөлөөлөл.....	13
3.7. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөө, үнэлгээ.....	14
3.8. Нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	14
4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ.....	16
4.2 Байгаль хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
4.3 Тохижуулах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.7 Осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөө.....	21
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	22
4.9 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.....	24
4.10 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
5.1 Хяналт, шинжилгээ хийх үзүүлэлтүүд.....	25
5.2 Хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	25
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	27

ОРШИЛ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОНХАЖЯ-наас 2014 оны 10 дүгээр сард гарсан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулан ажиллаж, 2020 онд хийгдсэн “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ”-ний дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү менежментийн төлөвлөгөөнд тухайн жилийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийж гүйцэтгэх ажил, шаардагдах зардлыг тооцож, оруулсан.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, хяналт-шинжилгээ хийх хуваарь, давтамж, сорьц дээж авах цэгийн байршил, баримтлах стандарт, түүнийг тодорхойлох арга аргачлал, шаардагдах зардлыг тооцож, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих нутгийн байгалийн болон нийгмийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, хяналтын байгууллагад бодитой мэдээлэл өгөх зорилготой юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан нь тухайн жилийн хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэхийн зэрэгцээ төрийн захиргааны төв болон холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавьсан шаардлага, санал хүсэлтийг хэрхэн хангасныг авч үзнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүр засаг захиргааны байгууллага, оршин суугчдад танилцуулан хэлэлцүүлж, тухайн оны 12 дугаар сарын 01-ний дотор хамгаална.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Хүснэгт 1.1. БОМТ-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал /мян.төг/
1. Байгаль хамгаалах төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлын багц		
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12,000.0
2	Орчны тохижилт нөхөн сэргээлийн төлөвлөгөө	19,500.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,640.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
5	Олон нийтэд тайлагнах хувааийн төлөвлөгөө	-
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ара хэмжээний төлөвлөгөө	-
8	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
9	Орчны хяналт шинэжилгээний хөтөлбөр	1,300.0
Нийт зардал		24,340


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Төслийн нэр:	Сайншанд Салхин парк
Төсөл хэрэгжүүлэгч:	“Сайншанд салхин парк” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019077051
Регистрийн дугаар:	528601
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Манлайбаатар Дамдинсүрэн гудамж, UB Tower 1309 тоот, Улаанбаатар 13374, Монгол улс Утас: +976075050055
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:	Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын нутаг

1.2 Төслийн байршил

Сайншанд салхин парк төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1005 м өндөр, Улаан толгойн хөндий хэмээх газарт Улаанбаатар хотоос зүүн урагш 460 км, Замын - Үүд дэх хилийн боомтоос баруун хойд зүгт 232 км, Сайншанд сумын төвөөс зүүн урагш 5 км зайд оршино. Салхин турбиныг Сайншанд хотын зүүн урд Улаантолгойн хөндий Хэцүү цавийн хуурай сайр бүхий ухаа толгодын ар нуруу тэгшивтэр өндөрлөг хэсэгт баруунаас зүүн хүртэл цуваа маягаар байрласан.



Зураг 1.1. Төсөл хэрэгжих газрын байршил. /Google Earth/



Зураг 1.2. Төслийн талбай



Зураг 1.3. Салхин турбин генератор

1.3 Төслийн хүчин чадал

Сайншанд салхин парк нь жилд 107.3 мянга гаруй айл өрхийн цахилгаан хэрэглээг хангах цэвэр эрчим хүчийг салхины хүчээр үйлдвэрлэснээр дулааны цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээс бий болох 222.64 мян.тн CO²-ын ялгаруулалтыг бууруулах, 78572 тонн нүүрсний хэрэглээг хэмнэхээр тооцоглогдсон. Төслийн хүчин чадлыг хүснэгт 1.2-т тоймлон үзүүлэв.

Хүснэгт 1.2. Төслийн хүчин чадлын тойм үзүүлэлтүүд

№	Техникийн үзүүлэлт	Тоон утга
1	Салхин сэнсний төрөл	Дани улсын Vestas V110-2.2MW
2	Салхин сэнсний хүчин чадал	2.2 МВт
3	Сэнсний диаметр	110 м
4	Сэнсний булын өндөр	95 м
5	Суурийн диаметр	17.9 м
6	Суурийн өндөр	2.76 м
7	Салхин сэнсний хоорондын зай, тоо ширхэг	Хоорондоо 400-800 м зайтай 25 ш
8	Сэнсний цахилгаан дамжуулах шугамыг газар доогуур явуулах талбайн хэмжээ, урт	9000 м * 0.75 м = 6750 м ²

1.3.1 Салхин сэнс суурилуулагдсан байдал.

25 ш салхин турбин хоорондоо 305-340 м зайтай байрлсан. Ашиглалтын үед турбиныг хянах, засварлах зорилгоор 4 м өргөн, 8 км урт сайжруулсан шороон зам тавигдсан. Төслийн үндсэн барилга байгууламж болох дэд станц, удирдлагын байр нь нийт 6695.0 м² талбайтай.

1.3.2 Дэд станцын хүчин чадал.

Дэд станц. Дэд станцын эзлэх талбай нь 6695.0 м² бөгөөд энд багаж төхөөрөмж, цахилгаан хэрэгслүүд болон шаардлагатай гадна байгууламжууд байгуулсан. Гадна байгууламжид үндсэн трансформатор, 110 кВ-ийн хуваарилах тоног, төхөөрөмж, 110 кВ-ийн тусгаарлагч, СТ, ПТ болон аянга зайлуулагч, гэрэлтүүлэгч шугамууд, газардуулагч, ослын нөхцөлд ажиллах зориулалттай дизель генератор зэрэг багтаж байгаа. Цахилгааны барилга нь 35кВ-ийн хуваарилах төхөөрөмжийн өрөө, релений тоног төхөөрөмжийн өрөө, SWG төхөөрөмжийн өрөө болон батарей байгууламжийн өрөөнөөс бүрдэнэ. Осол аваарын болон засварын үед нэмэлт цахилгааны эх үүсвэр хэрэгтэй тул ослын нөхцөлд ажиллах зориулалттай дизель генераторыг дэд станцын хашаанд суурилуулсан.



Зураг 1.4 35/110 кВ хуваарилах байгууламж



Зураг 1.5. Удирдлагын байр



Зураг 1.6. Галын сарай

Удирдлагын байр. Дэд станцаас 10 м зайд удирдлагын оффисын байрыг байгуулсан. Дэд станцын барилгын талбайн хэмжээ 342.3 м², гадуураа хашаагаар хамгаалагдсан нэг давхар байшин байх ба тэнд оффис, хурлын танхим, ээлжийн ажилчдын удмрдлагын хяналтын өрөө, 00-ын өрөө болон гал тогоо байрлана. Мөн ажилчдын усанд орох өрөө, дотор агуулах, жижиг засварын өрөө, граш зэргийг нэмэлт байдлаар зохион байгуулсан. Хашааны дотор болон гадна талд автомашины зогсоолыг битонон хучилттай хийж шийдвэрлэсэн байгаа.



Зураг 1.7. Гамшиг ослын үед цугларах талбай, тэмдэг тэмдэглэгээ



Зураг 1.8. Удирдлагын байрны гадна болон дотор зогсоол

1.4 Төслийн дотоод зам

Дотоод замыг төслийн хэрэгжилтийн хугацаанд салхин паркийн тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах, тэдгээрт засвар үйлчилгээ хийх зорилгоор WTG болон дэд станцуудын хооронд зорчиход ашиглана. Төслийн дотоод зам нь нийт 10.9 км урт юм 2022 онд урсгал засвар хийж замыг сайжруулсан.

1.5 Хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл

Хүснэгт 1.3.1 Төслийн хуулийн этгээд, төслийн товч танилцуулга

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1.Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	Сайншанд салхин парк ХХК
	2. Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар	5286301
	3.Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх
	4.Аж ахуй нэгжийн харьяаллын хаяг	Сайншанд салхин парк UB Tower, 13 давхар, 1309 тоот, Манлайбаатар Дамдинсүрэн гудамж 83/1, Баянзүрх дүүрэг, УЛААНБААТАР 13374, МОНГОЛ УЛС
	5.Захирлын нэр, утас цахим шуудангийн хаяг	Э.Мягмардорж, 95119681, myagmardorj.e@sainshandwindpark.mn
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим хаяг	С.Намжилмаа, 99032309 namjilmaa.sukhbaidy@sainshandwindpark.mn
	1.Төслийн нэр	Сайншанд салхин парк
	2.Төслийн харьяаллын байршил	Сайншанд морь барианы газраас урагш, Улаан толгой
	3.Төслийн ангилал а. Нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр б. Ил уурхай, далд уурхай, шороон орд в. Баяжуулах үйлдвэр	Хамааралгүй
1.2	4.Төсөл эхэлсэн огноо	2014 он
	5.Төсөл хэрэгжих хугацаа	25 жил
	6.Уул уурхайн хаалт эхлэх огноо	Хамааралгүй
	7.Хаалтын дараах зориулалт	Хамааралгүй
	8.ТЗЭҮ баталсан огноо	2011 он
	9.Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	174.8 сая кВт.цаг
	10.Ажилчдын тоо	19
	11.Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	24,340.0 мянган төг зарцуулна
	12.Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Авто зам
	• Замын урт,эхлэл төгсгөлийн цэг, чиглэл	10.9 км СТГ-ын дагуу
	• Шатахуун түгээгүүрийн тоо	Хамааралгүй
	• Шатахууны агууламжийн хэмжээ	Хамааралгүй

Хүснэгт 1.3.2 Химийн бодис хог хаягдлын менежментийн товч танилцуулга

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр хэмжээ <ul style="list-style-type: none"> - Тос тослогооны материал – 707л - Цэвэрлэгээний шингэн – 50л - Хөргөлтийн шингэн – 140л - Гидэрийн тос – 560л - Зэв арилгагч - 85л - Азотын хий - 280кг
	1. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө <ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдэлийн үед авах арга хэмжээ - Учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ 	Химийн бодисын эрсдэлийн менежмент <ul style="list-style-type: none"> - Химийн бодисыг хадгалах, ашиглах журам - Химийн бодисын асгаралт хянах журам - Ослын үед хариу арга хэмжээ авах менежментийн төлөвлөгөө - Монгол улсын хууль дүрмийн дагуу
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх дэлбэлэх материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Шатах тослох материалын агуулахтай <ul style="list-style-type: none"> - Трансформаторын тос – 1,000 л
3.3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ <ul style="list-style-type: none"> - Ахуйн хог хаягдал /Хатуу, шингэн/ - Үйлдвэрийн хог хаягдал /Хатуу шингэн/ - Аюултай хог хаягдал 	Хог хаягдлын жилийн дундаж хэмжээ <ul style="list-style-type: none"> - Ахуйн хатуу – 14 тн - Ахуйн шингэн – 205 тн - Аюултай – 310 кг
	1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Хог хаягдал зөөвөрлөх жилд зарцуулах зардал <ul style="list-style-type: none"> - 3,640.0 мянган төгрөг

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭЖ БУЙ ОРОН НУТГИЙН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ



Зураг 2.1. Төсөл хэрэгжиж буй аймгийн нийгэм эдийн засгийн тоон мэдээлэл



Зураг 2.2. . Төсөл хэрэгжиж буй аймгийн мэдээлэл

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаар мандалд үзүүлэх нөлөөлөл

Агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр төслийн талбайн хэмжээнд Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2016-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агаар бохирдуулагчид илрээгүй, төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага байна. Дуу шуугианы төвшин салхин турбинууд орчим шөнийн цагаар гадаад орчны шуугианы зөвшөөрөгдөх төвшнөөс давж болзошгүй байна. Гэхдээ салхин турбинаас 251 м алслахад шуугианы түвшин стандартад заасан хэмжээнд хүртэл буурах боломжтой ба судалгаанд хамрагдсан малчдын хотонд шуугианы түвшин зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байна. Цаашид салхин турбины аюулгүйн бүсийг мөрдүүлж ажилласнаар иргэдийг шуугианы нөлөөлөлд өртөх эрсдэлээс сэргийлэх боломжтой юм.

3.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл нь ахуйн хэрэглээнээс гарсан хатуу, шингэн хаягдал машин техник тоног төхөөрөмжийн шатах тослох материалын зохисгүй хэрэглээний улмаас үүссэн хаягдлаар газрын хөрс бохирдох магадлалтай. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг доор дурдав. Үүнд :

1. Салхин цахилгаан станц орчимд хүний үйл ажиллагааны нөлөөллөөр хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл үүсэх.

2. Хатуу хог хаягдлын цэг стандартын шаардлага хангаагүйгээс хөрс бохирдох, халдварт өвчин тархах нөхцөл бүрдэх зэрэг болно.

3.3. Гадаргын болон газрын доор усанд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны усан орчинд нөлөөгүй болох нь сүүлийн жилүүдэд хийгдсэн мониторинг судалгаагаар тогтоогдсон тул цаашид гар худгуудын мониторинг судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлагагүй гэж үнэлэгдсэн. Төслийн талбайд ашиглагдах ундны ус, хэрэглээний усаа гэрээт байгууллагуудаар зөөвөрлүүлэн ашигладаг.

3.4. Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Салхин цахилгаан станцын талбайд сүүлийн жилүүдэд хийгдсэн ургамлын нөмрөгийн хээрийн хэмжилт судалгаагаар төсөлд хамаарах газар нутгийн тээврийн хэрэгслийн замд хяналт сайн тавигддаг учир ургамлын нөмрөгт сөрөг нөлөөгүй, төслөөс үзүүлэх нөлөөлөл байхгүй гэж дүгнэгдсэн.

3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Амьтдад үзүүлэх сөрөг нөлөө нь амьтдын амьдрах орчинд ноцтой сүйрлийн түвшинд хүртэл нөлөөлөхгүй боловч газрыг цаашид байнга ашиглана., Харин ахуйн болон техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулсан тохиолдолд доорх байдлаар амьтны аймагт нөлөөлж болзошгүй юм.

3.6. Түүх соёлын дурсгалт зүйлд үзүүлэх нөлөөлөл

Сайншанд Салхин Парк төслийн талбай болох Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтан ширээ сумдын нутагт орших Үзүүр уулын Хэцүү цав “Бага завилаа” хэмээх газарт археологийн тандалт судалгаа хийсэн бөгөөд тус судалгаагаар төсөл хэрэгжих газарт болон нөлөөллийн бүсэд түүх соёлын өв, археологийн дурсгал, хэрэглэгдэхүүн олдоогүй. Хэрэв цаашид үйл ажиллагаа явуулах үед аливаа олдвор илэрсэн тохиолдолд барилгын ажлыг түр зогсоож, хамгаалалтад авч, мэргэжлийн байгууллагад хандан шаардлагатай арга хэмжээг авна.

3.7. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөө, үнэлгээ

Сайншанд салхин парк төслийн талбайн Зоогийн хоолой хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс 8-9 км зайд оршин байгаа талаар БОТБҮ-ний тайланд тэмдэглэснээс үзвэл ТХГН-т сөрөг нөлөө үзүүлэхгүй юм.

3.8. Нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Сайншанд Салхин Парк төсөл ашиглалтад орсноор Монгол Улсын нэгдсэн сүлжээнд жил бүр 185.0 сая кВт цаг цахилгаан эрчим хүч нийлүүлж, улмаар гаднаас импортлох цахилгааны хэмжээг бууруулж, улсын нэгдсэн сүлжээний ачааллыг бууруулж, нийт цахилгаан хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй цахилгааны хэрэгцээ шаардлагыг тасалдалгүй хангахад эерэг нөлөөлөл үзүүлэн, цаашлаад агаар мандал бохирдуулагч хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж, нүүрс хэмнэн, цэвэр ус хэмнэж байгаль орчин, нийгэм эдийн засгийн хөгжил, нийт иргэдийн эрүүл мэндэд шууд бус замаар эерэг нөлөөлөл авчирна.

Хүснэгт 3.1. Төслөөс орон нутгийн нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Үзүүлэлт	Ашиглалтын үе шат
Ажил эрхлэлт	Үйл ажиллагааны явцад түр болон байнгын ажлын байранд ажиллагсдыг дотоодоос түүний дотор орон нутгаас шалгаруулан авч ажиллуулдаг.
Зах зээл	Сайтын хангамжийн орон нутгаас хангах боломжтой хэрэгцээт зүйлсийг орон нутгийн компаниудаас ханган авдаг. Орон нутгийн төсөвт дараах татваруудыг төлнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> • НӨАТ • ХАОАТ • ААНБОАТ • ҮХЭХАТ
Татвар, төсөв	Байгаль орчны дараах төлбөр хураамж төлнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Газар ашигласны төлбөр • Бохир усны төлбөр

4 2
0

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ

4.1.1 Зорилго, зорилт

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах илрүүлэхэд оршино.

4.1.2 Хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагын БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө.

Үүнд:

1. Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох;
2. Нөхөн сэргээх, нөхөн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох;
3. Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох;
5. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
6. Байгаль орчныг хамгаалах талаар хийгдэж буй ажлын талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зэрэг асуудлыг тусгана.

4.1.3 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарчим

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг менежментийн бодлогоор хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаагаа журамлах үүднээс байгууллагын дотоод журам, дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол улсад мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байхаар боловсруулан холбогдох нэгж, хэлтэс, цех тасгуудад таниулан ажиллагсдыг сургаж, дадлагажуулна. Энэ бүхэнд дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэх экологийн орчныг сайжруулан, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, бий болгоно.
- Хүрээлэн буй орчныг хамгаалахад илүү анхаарч, байгаль орчны багц хууль, журам, дүрэм, БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийг мөрдөнө.

4.1.4 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, төсөв

Төсөл хэрэгжих хугацаанд хүрээлэн буй орчныг хамгаалах, сэргээх арга хэмжээ авна. Хүрээлэн буй орчныг хамгаалах, салхин сэнсний хэвийн ажиллагааг хангахын тулд байгаль орчин болон хүний эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд байнгын хяналт мониторинг хийж ажиллана. 2022 онд БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт мянган төгрөгийн зардал гарахар тооцов

4.2 Байгаль хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзлээ. БОННУ-ний тайланд төслийн цар хүрээнд бий болох сөрөг нөлөөллийн эрчим нь бага түвшинд байгаа бөгөөд сүйрлийн хэмжээнд хүрэх ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ нь тухайн төслийн онцлог, төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль, газарзүйн байршилтай холбоотой байх тул сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах боломжтой байна.

Хүснэгт 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ /	Нийт зардал /мян.төгрөг	Хэрэгжүүлэгч /хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт, аргачлал
1. ЦАГ УУР УУР, АМЬСГАЛ					
Аянга цахилгаан, салхи шуурга байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс салхин цахилгаан станцын тоног төхөөрөмжүүдэд гэмтэл, саатал учрах, гэнэтийн болон байгалийн гамшигт өртөх	Гамшиг ослоос хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, түүний дагуу сургалт, сургуулилт хийх, барилга байгууламж тоног төхөөрөмжийн газардуулгын байгууламжийг норм дүрэмд нийцүүлж ажиллах.	Салхин цахилгаан станц, түүний барилга байгууламж	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, “Гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийх журам” батлах тухай Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 67 тоот тогтоол
2. АГААРЫН ЧАНАР					
Төсөл хэрэгжих явцад ахуйн хатуу хог хаягдал, шингэн хог хаягдлаас үүдэлтэй тухайн орчинд эвгүй үнэр тархахаас сэргийлэх	Хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын битүү саванд хадгалах удаан хугацаанд хадгалалгүй тээвэрлүүлэх	Үйлдвэрийн талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	Сайншанд салхин парк ХХК	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/
Салхин турбины аюулгүйн бүсийг мөрдүүлж ажилласнаар иргэдийг шуугианы нөлөөлд өртөх, эрсдэлээс сэргийлэх	СТГ-ын аюулгүйн бүсэд малчид иргэдийг суурьшуулахгүй байх, ойр хавьд нутагладаг малчид иргэдэд мэдээ мэдээлэл хийх	Үйлдвэрийн талбай	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Агаарын тухай хуулийн 9-р зүйл
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					
Үйлдвэрлэлийн талбай орчимд хүний үйл ажиллагааны нөлөөлөөр хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл үүсэх	Авто замын хяналт үзлэгийг хийж, авто замын урсгал засварыг хийж өөрсдийн замаара байнга зорчиход хяналт тавьж ажиллах	Үйлдвэрийн талбай	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	“Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам” батлах тухай Засгийн газрын 2018 оны 379 тоот тогтоол
	Талбайд ажил гүйцэтгэх жолооч нарыг талбайд хурдаа тохируулж зорчих, зөвшөөрөгдсөн замаас өөр замаар зорчихгүй байх зааварчилгаа өгч ажиллах				

4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС					
Бохир усны хадгалах савнаас бохир ус хальж асгарч хөрс бохирдон улмаар гүний ус бохирдох сөрөг нөлөөлөлтэй	Бохир усны хадгалах хэмжээг тогтмол шалгаж тусгай зөвшөөрөл бүхий компаниар тээвэрлүүлэх Ус бохирдуулсны гэрээ байгуулан дүгнэлт гаргуулан ажиллах	Бохир ус хадгалах ёмкост	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	Сайншанд салхин парк ХХК	“Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах” журам батлах тухай БОАЖС, ЭМС-ын 2018 оны А-82, А128 тоот хамтарсан тушаал
Шатахуун тослох материал алдагдсанаас үүдэн усны шинж чанарт нөлөөлөх	Техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийлгэх асгаралтыг хянаж, асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах Тос тосолгооны хаягдлыг тусгай зориулалтын цэгт хадгалж, хуулийн хугацаанд тээвэрлүүлэх	Үйлдвэрийн талбай	-	Сайншанд салхин парк ХХК	Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/
5. УРГАМЛАН НӨМРӨГ					
Үйлдвэрийн талбайд үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөллөөр хөрс, ургамал халцрах, тахлагдах, зам харгуй гарах	Үйлдвэрийн үйлчилгээний тээврийн хэрэгслийг зөвшөөрөгдсөн замаар зорчуулж хяналт тавих Үйл ажиллагаанаас хөрс ургамалд нөлөөлхүйц ажил гүйцэтгэх шаардлага гарвал зохих байгууллагаас зөвшөөрөл авах, сүйтгэгдсэн талбайг нөхөн сэргээх	Үйлдвэрийн талбайд	-	Сайншанд салхин парк ХХК	MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамлыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага

5. АМЬТНЫ АЙМАГ					
Шувуу идэш тэжээлээ хайх болон үүр засах гэж яваад сэнсэнд өртөж үхэх	Сар бүр сэнсний талбайгаар сэг зэм, хог хаягдлыг 7 хоног бүр үзэж шалган амьтны сэг зэм илэрвэл орон нутгийн байгаль орчны байцаагчид мэдээлж ажиллах	Үйлдвэрийн талбайд	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Олон улсын шаардлага: НҮББАХ – Салхин сэнсний паркт сарьсан багваахайг харгалзан үзэх нь, 2014 Байгаль орчны хамгаалах тухай Монгол улсын хууль Амьтны тухай Монгол улсын хууль
	Байршуулсан шувууны үүрэнд хяналт мониторинг хийж, арчилж тордох	Зүүн баян сумын нутагт	Үйл ажиллагааны зардал		
	Талбайд шувууны үхэл, шувуу үүрлэсэн байгаа эсэхийг тогтмол үзэж шалгаж, бүртгэх	Үйлдвэрийн талбайд	Үйл ажиллагааны зардал		
	ЦДАШ-ын шувуу үргэгчийн бүрэн бүтэн байдалд сар бүр хяналт хийх	ЦДАШ	Үйл ажиллагааны зардал		
	Шувууны мониторинг судалгаа хийх	Үйлдвэрийн талбайд	-		
6. БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН					
Байгаль орчны мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны сөрөг нөлөөлө байгаа эсэхийг тогтоолгож сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах	Үйлдвэрийн талбайд	12,000.0	Мэргэжлийн байгууллага		
Сэргээгдэх эрчим хүчний салбарт орчин үеийн шинэ технологи нэвтрэх, эдийн засгийн үр ашиг нэмэгдэх, хорт хий ялгаралыг багасгах тодорхой хувь нэмэр оруулах	Бүс нутгийн эрчим хүчний системд	-	Сайншанд салхин парк ХХК	“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр” “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”	
Салхин цахилгаан станц нь бүс нутгийн цахилгаан дамжуулах сүлжээний хүчдэлийн түвшинг тогтворжуулах, сүлжээний горим үр ашгийг дээшлүүлэх					
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлын нийт дүн		12,000.0			

4.3 Тохижуулах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө

Салхин цахилгаан станц барьж байгуулах үйл ажиллагааны хүрээнд нийт 25 ш салхин турбин суурилуулсан. Сайншанд салхин цахилгаан станц нь ойрын 5 жилд 2500 м2 талбайд ногоон байгууламж тариалхаар төлөвлөн ажиллаж байгаа ба энэ жилд Дорноговь аймгийн Эрдэнэ суманд ШАМБАЛА төслийн талбайд мод тариалуулан эзэмшихээр төлөвлөсөн.

Уг төсөл нь 3кВт-ын сэргээгдэх эрчим хүчний системийг ашиглан автомат дуслын усалгааны системтэй, 24 цагийн харуул хамгаалалттай, нийт 5 жилийн усалгаа арчилгаатайгаар таны авсан модыг тарих ба цөлжилтөөс сэргийлэх, хүлэмжийн хийг бууруулах нөлөөтэй юм.

Хүснэгт 4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт

Биелэлтийн шалгуур	Бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт, аргачлал
Төсөл хэрэгжиж буй талбай болон орон нутгийн байгаль орчинд эерэгээр нөлөөлөх юм.	Мод тариалах	Орон нутагтай хамтран мод тариалах	19,500.0	Сайншанд салхин парк ХХК	MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамалыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага,
Нийт зардал		19,500.0			

4.4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй. Энэхүү төсөл хэрэгжсэнээр хүлэмжийн хийн ялгаралт буурч, нүүрс болон усны хэрэглээ багасах ба эдгээр эерэг нөлөөлөл нь үлдэгдэл сөрөг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалахгүй байх үндэслэл болно.

4.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг төслийн барилга угсралтын ажил эхлэхээс өмнө буюу 2017 онд хэрэгжүүлж дуусгасан бөгөөд цаашид нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөх шаардлагагүй болно.

4.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчимд түүх, соёлын өв, дурсгалт зүйлс, археологи, палентлогийн олдвор бүхий газар байхгүй тул сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон тул зардал төлөвлөх шаардлагагүй болно.

Хэрэв төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

4.7 Осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөө

4.7.1 Урьдчилан сэргийлэх менежмент

Төсөл хэрэгжүүлэх явцад гарах эрсдэл нь технологийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй тул осол, эрсдэлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралтай арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж, ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах, үйл ажиллагаандаа дотоод хяналт тавина. Түүнчлэн гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.7.2 Эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн хугацаанд үүсэж болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд авах арга хэмжээний төлөвлөгөө.

Хүснэгт 4.3. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний зардал

Бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал мян.төг	Хэрэгжүүлэгч /хамтран хэрэгжүүлэгч /	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт, аргачлал
Шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл багажаар ажиллагсдыг хангах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Аюулгүй ажиллагаа хангагдана.	ХАБЭА-н заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль,
Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, бэлэн байлгах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Аваар ослын үед анхны тусламж бүрэн авах боломжтой болно.	
Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар Тайлбарлаж таниулах, сургалт зохион байгуулах, ажиллагсдыг шаардлагын дагуу сургах	Бүх ажиллагсдад	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Аюулгүй ажиллагааг хангах	
Онцгой байдлын үед ажиллах дадлага сургалт хийх	Бүх ажиллагсдад				
Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Төслийн талбай, барилга байгууламжид	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Гал түймрийн аюулаас сэргийлнэ.	
Химийн бодисын ашиглалт, хадгалалтад тогтмол хяналт тавьж, бүртгэн холбогдох хууль дүрмийн дагуу мэдээллийг өгч ажиллах	Химийн бодисын хадгалалт	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК	Химийн бодисыг стандартын дагуу хадгалж, ашиглах	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, дүрэм

4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатай арга замаар зайлуулах, хадгалах зорилготой.

- Хог хаягдлыг хэрхэн удирдан зохион байгуулахыг (цуглуулах, ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх, зайлуулах болон бүртгэх) тодорхойлох
- Үйл ажиллагааны сайн туршлагыг нэвтрүүлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах зарчмыг баримтлах замаар үүсэж буй хог хаягдлын хэмжээг хянах;
- Хүний эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хог хаягдлыг хэрхэн цуглуулах, ангилан ялгах, түр хадгалах талаар зааварчилгаа өгөх

Хүснэгт 4.4. Хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Шаардагдах зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч /хамтран хэрэгжүүлэгч /	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	Энгийн хог хаягдлын цэг	-	Сайншанд салхин парк ХХК	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох тогтоол, дүрэм, журам
Ахуйн хатуу хог хаягдлыг тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээний дагуу тогтмол зайлуулах	Энгийн хог хаягдлын цэг	Жилд 15 удаа 900.0	Сайншанд салхин парк ХХК	Орчин бохирдохоос сэргийлнэ	
Ажиллагсдын бие засах газар, бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Ахуйн шингэн хог хаягдлын цэг	Жилд 100.0	Сайншанд салхин парк ХХК	Орчин бохирдохоос сэргийлнэ	
Ахуйн шингэн хаягдлыг тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай шингэн хаягдал тээврийн үйлчилгээний гэрээний дагуу тогтмол зайлуулах		Жилд 48 удаа 2,640.0	Сайншанд салхин парк ХХК		
Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан ажиллах	Ахуйн хог хаягдал	-	Сайншанд салхин парк ХХК	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна	
Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	Нийт ажлагсад	-	Сайншанд салхин парк ХХК	Ажиллагсад хог хаягдлыг зүй зохистой хаяж хэвших	
Аюултай хог хаягдал түр хадгалах цэгт гэнэтийн осол гарсан тохиолдолд аюулгүй, хоргүй, халдваргүй болгоход ашиглах багаж, хэрэгсэл бэлэн байлгах	Аюултай хог хаягдал хадгалах тусгай цэг	Үйл ажиллагааны зардал	Сайншанд салхин парк ХХК Гэрээт компани	Аюултай хог хаягдлаас байгаль орчин хүн амьтан хордохоос сэргийлнэ	
Аюултай хог хаягдлыг зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ тогтоосон маягтын дагуу дагалдах бичиг үйлдэж хуулийн хугацаанд тээвэрлүүлэх	Аюултай хог хаягдлын тусгай цэг	-	Сайншанд салхин парк ХХК Гэрээт компани		
Хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааны зардал, мян.төг			3,640.0		

4.9 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

Салхин паркийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь сумын удирдлагууд, иргэд, оршин суугчид бөгөөд сонирхогч болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

БОМТ-г орон нутагт танилцуулах, хэлэлцүүлэх ажлын зардал. Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг жилд нэг удаа зохион байгуулна. Иргэдэд мэдээ мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан өгч ажиллана.

Хүснэгт 4.5. БОМТ-ний хэрэгжилтийн нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах Төлөвлөгөө

Сонирхогч, оролцогч талууд	Хэрхэн хийх	Мэдээний агуулга	Оролцогч талууд танилцуулах хэлбэр
Тухайн нутаг дэвсгэрт амьдардаг иргэд, малчид болон сумын удирдлагууд	Биечлэн мэдээлэл хийх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар	<ul style="list-style-type: none"> ~ Орон нутгийн сумын салчид ирэгдийн уулзалтад оролцож мэдээлэх ~ Орон нутгийн удирдлагуудад уулзалт товлож мэдээлэх ~ Төслийн үйл ажиллагаатай танилцах хүсэлт бүхий иргэд хүмүүст мэдээллийн цахимаар хүргэх
Дорноговь аймгийн Сайншанд сумын сумын БОАЖГ-т	Тайлан хянуулах, хэлэлцүүлэх, батлуулах	БОМТ-ний биелэлтийн тайланг танилцуулж, дүгнүүлэх	~ БОМТ-ний биелэлтийн тайлан танилцуулах тов зарласан өдөрт танилцуулж ажиллана
БОАЖЯ-ны ХБОБНГ-т	Тайланг хүргүүлэх, батлуулах	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан, ирэх оны төлөвлөгөө	~ Тухайн жилийн БОМТ биелэлтийн тайланг баталгаажуулан, дараа оны төлөвлөгөө болон түүнд шаардагдах хөрөнгө, зардлыг хянан, батлуулах, зөвшөөрөл авах
Олон нийтэд	Мэдээлэл хүргэх	Масс мессеж болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх	<ul style="list-style-type: none"> ~ Орон нутгийн сумын салчид ирэгдэд мэдээлэл хүргэх ~ Төслийн үйл ажиллагаатай танилцах хүсэлт бүхий иргэд хүмүүст мэдээлэл хүргэх

4.10 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Удирдлагын менежмент. Төслийн бүтцэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны хяналт, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ажиллаж, байгаль орчин, аюулгүй байдлын зохион байгуулалт, удирдлагын баримт бичгийн боловсруулалтыг хийж, хяналт тавьж ажиллана.

Байгаль орчны хяналт-мониторинг, БОННҮ-д заасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны мэргэжлийн байгууллагатай хамтран тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

- Ан амьтдын байршил, тархалт тоо толгойг тогтоон төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.
- Тусгай зөвшөөрөлтэй талбайд явагдсан хууль бус ангийн талаарх үйл ажиллагааны мэдээллийг холбогдох газруудад шуурхай мэдээлж бүртгэлд авч ажиллах.
- Зэрлэг амьтадад зориулж усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10^{1.1}-т заасны дагуу Байгаль орчны аудитын дүгнэлтийн зөвлөмжийн хэрэгжилтийг зөвлөмжид заасан хугацаанд тусгайлан ирүүлэх.
- Химийн бодисын агуулахын дүгнэлтийг 2023 оны 04-р сарын 20-ны дотор ирүүлэх.

5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны явцад гарах өөрчлөлтүүдийг тодорхойлох зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцож, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Төсөл хэрэгжих явцад орчны хяналт шинжилгээг хөтөлбөрт тусгасан хугацаа болон аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ. Энэхүү хөтөлбөр нь төслийн үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэх ба тухайн жилд хийсэн хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж байх нь цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгоход дөхөм болно.

“Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу “Сайншанд салхин парк” ХХК нь орчны хяналт-шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хийлгүүлж итгэмжлэгдсэн лабораториудад шинжилгээг хийлгэн ажиллана.

5.1 Хяналт, шинжилгээ хийх үзүүлэлтүүд

Агаарын чанар. Төслийн талбайн ойр орчимд үүсэх тоосжилтын агууламж болон тээврийн хэрэгслээс ялгарах агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээг тогтмол хянаж байх шаардлагатай.

Усны бохирдол. Төсөл хэрэгжих явцад ахуйн бохир ус, хог хаягдал болон ШТМ-аар хөрс, ус бохирдох нөхцөлийг хянах шаардлагатай. Эдгээр нөлөөллийн улмаас хөрс, усанд үүссэн бохирдлыг тогтоохын тулд хог хаягдлыг түр хадгалах цэгийг зөв байршуулж, байнга хяналтад байлгах хэрэгтэй.

Хөрсний эвдрэл, бохирдол. Шимт хөрсийг хадгалах үйл ажиллагаа стандартын шаардлагыг хангаж байгааг хянахад MNS 5916:2008 стандартыг мөрдөнө. Төслийн үйл ажиллагааны цар хүрээнд ШТМ-ын ашиглалтаас сэлбэг, шатахуун хадгалах агуулахын орчинд хөрсний бохирдол үүсэх нөхцөлтэй тул бохирдлын цар хүрээг тэлэхгүй байх үүднээс байнгын хяналт тавих хэрэгтэй. Мөн ахуйн бохирдол орчны хөрсийг бохирдуулах нөхцөлтэйг анхаарч хяналт тавьж ажиллах, гадаргын урсац үүсгэхгүй байхад чиглэсэн хяналтыг явуулна.

5.2 Хяналт, шинжилгээний хөтөлбөр

“Сайншанд салхин парк” ХХК төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд үүнд нийт 1,300.0 мян.төг-ийн зардал гаргана.



Сайншанд Салхин Парк төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023 он

Хүснэгт 5.1. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР				
Хорт хий, ББ-ууд: Тоос /PM10, PM2.5/ CO2 SO2 NO2 агууламж тодорхойлох	Төслийн талбайгаас	Жилд 1 удаа 2 цэгээс	350.0	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага/MNS 5885 : 2008/
2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС				
Унд-ахуйн хэрэглээнд ашиглаж байгаа усны шинжилгээг тогтмол хийлгэх	Ажилчдын унд-ауйн болон төслийн талбай орчмын худгаас дээж авах (2 цэгээс)	Жилд 1 удаа 2 цэгээс	350.0	Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлагууд болон чанарын хяналт MNS 900:2005
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ				
Бичил биетний тоо (1гр-д) Колититр Cl.perferingens титр тодорхойлох	Төслийн талбайгаас	Жилд 1 удаа 2 цэгээс	300.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008. Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991
4. УРГАМЛАН НӨМРӨГ				
Ургамлын зүйл, бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, үнэмлэхүй болон үржил шим тодорхойлох	Төслийн талбайгаас	Жилд 1 удаа 2 цэгээс	300.0	Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991
ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, мян.төг			1,300.0	



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал, 2014
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний аргачлал, 2019
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, 2019
4. Сайншанд салхин парк төслийн БОННУ-ний тайлан, “Грийн ассесмент” ХХК, 2020 он